



Canada


Ковид-19 цар тахлын нөхцөл байдал ба жендэр

Г.Байгалмаа, MERIT төслийн ажилтан

Агуулга

- Өнөөгийн нөхцөл байдал
- Ковидын нөлөө зарим нэгэн тоо баримтаар:
 - Гэрийн хөлсгүй хөдөлмөр
 - Хүүхдийн оролцоо
 - Боловсрол
 - Бизнес
 - Хөдөлмөр эрхлэлт
 - Эрүүл мэнд /эрчүүд, вакцин/
- Сайн туршлага

Ковидын нөхцөл байдал



- Өнөөдрийн байдлаар 148 сая гаруй хүнд халдвар тарааж, 3.1 сая гаруй хүний аминд хүрч, 115 сая хүртэл хүнийг нэн ядуу байдалд оруулах төлөвтэй байна.
- Жендэрт суурилсан хүчирхийлэл, ажилгүйдэл нэмэгдэж, хамгийн ядуу, эмзэг бүлгийнхэн авах эрүүл мэнд, халамж үйлчилгээний хүртээмж буурсан.
- Хүмүүс вирусын халдвар авахаас эмээж эрүүл мэндийн үйлчилгээнд хандахгүй байна. Тухайлбал: Хумхаа өвчний оношлогоо 31%, жирэмсэн эмэгтэйчүүдийн жирэмсний өмнөх үзлэг 43% буурсан байна.
- **Таамаглал:** Ирэх хэдэн арван жилийн хугацаанд Ковидын сөрөг нөлөө байсаар байх болно.

Хөл хорио / Гэрийн хөлсгүй хөдөлмөр

- 3 тивийн 47 улсаас авсан судалгаа

Хоол хийх бэлтгэх



Эмэгтэй		Эрэгтэй
32%	Нэмэгдсэн	18%
17%	Ихэнхдээ үүнийг хийдэггүй	48%



Гэр бүлийн хэрэгцээнд зориулж худалдан авалт хийхэд оролцох

Эмэгтэй		Эрэгтэй
25%	Нэмэгдсэн	22%
23%	Ихэнхдээ үүнийг хийдэггүй	29%



Цэвэрлэгээ (хувцас угаах, гэрийн ажил г.м)



Эмэгтэй		Эрэгтэй
45%	Нэмэгдсэн	35%
13%	Ихэнхдээ үүнийг хийдэггүй	33%



Гэрээ чимэглэх, засвар үйлчилгээ хийх

Эмэгтэй		Эрэгтэй
29%	Нэмэгдсэн	24%
29%	Ихэнхдээ үүнийг хийдэггүй	33%



Хөл хорио / Гэрийн хөлсгүй хөдөлмөр

- Бүгд оролцож байгаа боловч эмэгтэйчүүд бас л илүү хувьтай байна. 3 тивийн 47 улсаас авсан судалгаа

Хүүхдээ халамжлах, хөхөөр хооллох, асрах, бусад халамж туслалцаа үзүүлэх



Эмэгтэй		Эрэгтэй
36%	Өссөн хувь	30%
36%	Ихэнхдээ үүнийг хийдэггүй	48%




Хүүхэдтэйгээ тоглох, ярилцах, уншиж өгөх



Эмэгтэй		Эрэгтэй
34%	Өссөн хувь	28%
36%	Би үүнд оролцдоггүй	42%



Заах сургах



Эмэгтэй		Эрэгтэй
32%	Өссөн хувь	29%
40%	Ихэнхдээ үүнийг хийдэггүй	44%



Насанд хүрсэн гэр бүлийн гишүүдэд үзүүлэх сэтгэл зүйн дэмжлэг




Эмэгтэй		Эрэгтэй
34%	Өссөн хувь	31%
27%	Би үүнд оролцдоггүй	35%



Гэрийн ажилд оролцох / Охид, хөвгүүд – Монгол улс

Цар тахлын үед ажил үүрэг нь нэмэгдсэн гэж хариулсан хүүхдүүдийн эзлэх хувь



Эх сурвалж: Коронавируст цар тахлын үр нөлөөний үнэлгээ, Хүүхдийг ивээх сан, 2020

Ковид ба боловсрол /Дэлхийд

- 1.6 тэрбум суралцагчдад нөлөөлсөн КОВИД-19 хямралын эсрэг авсан хариу арга хэмжээнүүд бүх суралцагчдыг хамруулахад хангалттай анхаарал хандуулаагүй байна.
- Covid-19 цар тахлын улмаас боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагаа анги, танхимд явагдах боломжгүй болж сургуулиа хаасан улсын тоо 2020 оны 3-р сарын 15-нд 53, 4-р сарын 15-нд 190, 5-р сарын 15-ны байдлаар 158 болсон байна.
- Цар тахлын тархалтын оргил үед дэлхийн нийт суралцагчдын 91,3 хувь нь сургуульд явах боломжгүй, онлайн болон бусад ямар нэгэн хэлбэрээр сургалтаа үргэлжлүүлж, зарим улсад хязгаарлагдмал боломжоос хамаарч сургалт зогсоход хүрсэн байна. [/en.unesco.org/](https://en.unesco.org/)

Ковид ба боловсрол /Монгол улс

- Боловсролын салбарын дийлэнх хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна.


Сургалтын байгууллагын ангилал	Нийт	Үүнээс эмэгтэй	Эмэгтэйчүүдийн эзлэх хувь
Нийт	49,871	40,000	80.2%
Цэцэрлэг	8,068	7,809	96.8%
Ерөнхий боловсролын сургууль	32,085	26,149	81.5%
Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага	2,388	1,551	64.9%
Их, дээд сургууль, коллеж	7,330	4,491	61.3%

Эх сурвалж: 1212.mn, YCX, 2020 оны байдлаар


- Боловсролын үйлчилгээнд гарсан үйлчилгээ нь багш нарыг ачааллыг нэмэгдүүлж, сэтгэл санааны түгшүүр стресс бухимдал үүсгэхэд хүргэсэн.
- 2020 оны 11 сард авсан судалгаагаар теле хичээл зааж эхэлснээс хойш эмэгтэй багш нарын 79,2%, эрэгтэй багш нарын 60% ажлын ачаалал нэмэгдсэн гэж хариулсан.
- “Өнгөрсөн жил манайх хүү 3-р ангид байсан. Түүнийг теле-хичээлийг хийлгэнэ гэдэг том асуудал, бөөн стресс. Манай нөхөр хүүгийн хичээлд ер санаа зовсон шинжгүй, хичээлд нь туслахгүй байгаа нь надад давхар уурлах шалтаг болдог”* Залуу эмэгтэй, Хэнтий

Ковид ба жендэрт суурилсан хүчирхийлэл

Цагдаагийг шуурхай дуудлагын 102, ГБХ-ийн дуудлагын тоо, өдөр бүрээр, 2020 оны 10 сарын сүүлээс 12 сарын эхэн хүртэл



ГБХ-ийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил 2020 оны 10, 11 сар



Source: Central Police. 2020. Monthly report on domestic violence.

Ковид ба бизнесийн орчин


ЖДҮ-дэд тулгамдаж буй бэрхшээлүүд



Эх сурвалж: Хатуу хөл хорионы үеийн бизнесийн нөхцөл байдал судалгааны тайлан, МҮХАҮТ, 2020

Ковид ба бизнесийн орчин

Орлого нь буурсан ААН, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар



- Орлого нь буурсан ААН-үүдийн дор хаяж **63,5%-ийг эмэгтэйчүүд** зонхилсон бизнес эзэлж байна.

Эх сурвалж: ААН-ийн үйл ажиллагаанд үзүүлж буй Корона вирусийн нөлөөлөл II шатны судалгаа, YCX, 2020

Ковид ба хөдөөгийн өрхийн орлого

Хөдөөгийн өрхийн орлогын бүтэц (2019 дотор талд, 2020 гадна талд)




- Нөхөр, эхнэр хамтран оролцдог
- Түүхий эдийн экспорт зогссон, үнийн уналтаас болж өрхийн орлого **20%-иар** буурсан.

Тэмдэглэл: 2019 оныг дотор талын тойрог, 2020 оныг гадна талын тойргоор харуулав.
Эх сурвалж: 1212.mn, YCX, 2020 оны 3-р улирлын байдлаар

Ковид ба хөдөлмөрийн зах зээл

Бага цалинтай ажилчдын хувь



Эх сурвалж: 1212.mn, УСХ, 2019 оны байдлаар


- Эмэгтэйчүүд голлон орлого олж буй салбар хүүхэд асрагч, үйлчлэгч, гал тогооны туслах ажилтан
- Тэдэнд хадгаламжийн хуримтлал үүсгэх боломж байхгүй.

Хөл хорион эхэн үед ихэнх ажил олгогчид дөрвөн эмэгтэй ажилчин тутмын нэг нь гэрээсээ болон богиносгосон цагаар ажиллах боломж олгосон давуу талтай

Боловч

Хүүхэд асрах үүргийг зөвхөн эмэгтэйчүүдэд үүрүүлсэн жендэрийн тухай **хэвшмэл ойлголтууд** нийгэмд улам гүнзгийрэх нэг хүчин зүйл болох магадлалтай

Ковид ба эрчүүд



- www.dw.com
- Дэлхийн эрүүл мэндийн 50/50 судалгаагаар эмэгтэйчүүд вирусын халдварыг эрэгтэйчүүд шиг олон удаа авдаг болохыг баталжээ. Гэхдээ эрэгтэйчүүд COVID-19-ийн хүнд хэлбэрийн халдвар авч, халдварын улмаас нас барах магадлал өндөр байдаг
- 70-79 насны ангилалд нас баралтын тоонд эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдээс дор хаяж хоёр дахин их байна.
- Эмэгтэйчүүдийн дархлаа нь эрэгтэйчүүдээс илүү тэсвэртэй байдаг. Үүний гол шалтгаан нь эмэгтэй бэлгийн даавар эстроген юм. Харин эр даавар тестостерон нь бие махбодийн өөрийн хамгаалалтыг дарангуйлдаг.
- Буруу амьдралын хэвшил

Ковидын нөлөө / Вакцин – Монгол улс

- www.worldbank.org/en/country/mongolia
- Хүн амын коронавирусээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх мэдлэг харьцангуй өндөр байгаа ба судалгаанд хамрагдсан **5 хүн тутмын 4 нь Ковид-19-ийн** эсрэг баталгаатай вакциныг үнэ төлбөргүй хийлгэх хүсэлтэй байв.
- Судалгаанд оролцогчдын **61 хувь нь** вакциныг төлбөртэй байсан ч хийлгэнэ гэжээ. Вакцины **баталгаатай байдалд эргэлзэх эргэлзээ** хот, суурин газрын оршин суугчдын хувьд хөдөөтэй харьцуулахад илүү өндөр байна.

Сайн туршлага /Жишээ

- Чиглэсэн төсөл, хөтөлбөрүүд
 - Жендэрийн Үндэсний Хороо, Азийн сангаас Канадын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх” төсөлтэй хамтран ТББ-уудад зориулсан тэтгэлэгт. Энэхүү тэтгэлэг нь “Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөг даван туулахад эмэгтэйчүүд, охидод туслах төрийн бус байгууллагуудын шинэ санаа, санаачлагыг дэмжих” зорилготой.
- Уян хатан ажлын цаг, гэрээс ажиллах туршлага
- COVID-19 өвчний дэгдэлт дэх жендэрт суурилсан хүчирхийлэл (GBV) мэдэгдэх. Тухайлбал: “Халаасны хөтөч” програм
- Техникийн дэвшилтэнд технологи ашиглалт
 - ZOOM, Google meeting, Thinkific

Эх сурвалж

- <http://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/17162.pdf>
- <https://mongolia.unfpa.org/mn/news>
- <https://reliefweb.int>
- <https://www.worldbank.org/mn/country/mongolia/brief/monitoring-covid-19-impacts-on-households-in-mongolia>
- <https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/library/-covid-19-impact-on-women-and-girls-in-mongolia--study.html>
- НҮБ-ын эмэгтэйчүүдийн КОВИД-19-ийн нөлөөнд үзүүлэх шуурхай жендэрийн үнэлгээ, 2020 оны 4-р сараас 11-р сар хүртэл
- Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн жендэрийн тэгш байдалд Ковид-19 цар тахлын үзүүлж буй нөлөө
- <https://www.dw.com/en/why-do-more-men-die-from-covid-19/a-53952130>



Canada

Mongolia:
Enhancing Resource
Management through
Institutional Transformation

Address: Floor 3, National Times News Tower Khudaldaanii gudamj, Khoroo 1
Chingeltei district, Ulaanbaatar-15160 Mongolia

Phone: 7610-5000